

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

1. Монгол улсын үндсэн хуульд нийгмийн хөгжлийн зорилгыг юу гэж тодорхойлсон бэ? (1оноо)
 - A. Ардчилсан нээлттэй нийгэм цогцлуулах
 - B. Эрх чөлөөт хөгжингүй нийгэм байгуулах
 - C. Ардчилсан, хүмүүнлэг энэрэнгүй нийгэм бий болгох
 - D. Хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх
 - E. Ардчилсан, шударга, энэрэнгүй нийгмийг цогцлуулах
2. Нийгмийн бүлгийн тухай ойлголт аль нь вэ? (2 оноо)
 - A. Ижил зорилго бүхий 6 доошгүй хүмүүсийн хамтын ажиллагаа
 - B. Нэг зорилго нэг ижил эрх ашиг, сонирхол, үнэт зүйл бүхий хүмүүсийн нэгдэл
 - C. Өөр өөр эрх ашиг, сонирхол бүхий хүмүүсийн нэгдэл
 - D. Нэг нутаг дэвсгэр дээр амьдарч байгаа хүмүүсийн цогц
 - E. Дээрхи бүгд
3. Үндэстэн бүрэлдэх нөхцөлд тохирохгүй зүйл дурдсан бол аль нь вэ? (1оноо)
 - A. Нутаг дэвсгэртэй байх
 - B. Хэл соёлын нийтлэг
 - C. Эдийн засгийн нийтлэг
 - D. Сэтгэл зүйн нийтлэг
 - E. Намын харъяалтай байх
4. Өргөжсөн гэр бүлийн хэлбэр аль нь вэ? (2 оноо)
 - A. Нэг эрэгтэй олон эхнэртэй байх
 - B. Нэг эмэгтэй олон нөхөртэй байх
 - C. Олон эхнэртэй, олон нөхөртэй байх
 - D. Нуклер гэр бүлийн гишүүдийн хамт эмэг, эцэг эх ач зээ, авга нагац, үеэл ах дүү зэрэг төрөл төрөгсөд нь багтах
 - E. Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн харилцааг зохицуулж үр удмаа бий болгоход чиглэсэн эрэгтэй эмэгтэй хоёр хүний тогтвортой холбоо
5. Хөдөлмөр материал баялгийг бүтээгч хүнийг өөрийг нь бүтээсэн гэж хэн хэлсэн бэ? (1 оноо)
 - A. Платон
 - B. Күнз
 - C. К. Маркс
 - D. Ф. Энгельс
 - E. З. Фрейд
6. Эдийн засгийн тогтолцоог уламжлалт, зах зээлийн, төлөвлөгөөт, холимог гэж ангилан судалж байгаа нь шинжлэх ухааны танин мэдэхүйн ямар аргыг хэрэглэж байна вэ?(1оноо)
 - A. Анализ
 - B. Синтез
 - C. Индукци
 - D. Дедукци
 - E. Загварчлал
7. Дедукцийн аргын мөн чанарт аль нь тохирох вэ? (2 оноо)
 - A. Тусгай тусгай юм үзэгдлүүд, баримтуудаас ерөнхий үндэслэл дүгнэлт гаргах
 - B. Ямар нэг онол, үндэслэл, ерөнхий дүгнэлт зэргээс түүнд холбогдох бүлэг юмуу, бодгаль зүйлд хамруулсан дүгнэлт хийх
 - C. Бүх л зүйлийг бүрэлдэхүүн хэсэг, нэгжид нь сэтгэхүүдээ салган хувааж задлах
 - D. Танин мэдэгдсэн нэгж, салангад хэсгүүдийг нэг цогцод оруулан сэргээн холбож нэгтгэн дүгнэх
 - E. Нийгмийн үзэгдэл, үйл явцад судлаач өөрөө оролцох юм уу, оролцохгүй ажиглах замаар мэдээлэл цуглуулах
8. Нийгмийн микро бүлэгт (явцуу утгаар) хамаарах нь аль вэ? (1 оноо)
 - A. Анги давхраа, овог аймаг, ястан, үндэстэн
 - B. Хүн ам зүй, боловсрол мэргэжлийг багтаасан нийгмийн нийтлэгүүд
 - C. Анги давхраа, биеийн тамирын баг, найз нөхдийн бүлэг
 - D. Гэр бүл, үйлдвэрлэлийн хамт олон
 - E. Аль нь ч биш

9. Нийгмийн институтын зөв тодорхойлолтыг олно уу. (1 оноо)
 А. Нийгмийн хувьсгал, хөгжил нь нийгмийн институтын байгаль дахь шалгарал лугаа
 В. Нийгмийн үндсэн хэрэгцээг хангах, нийгмийн хэм хэмжээг зохицуулах чиг үүрэг бүхий тохируулагч байгууламж
 С. Нийгмийн хөгжил дэвшлийг хангагч бүх хүрээнүүдийн нэгдэл
 D. Нийгмийн үндсэн ба үндсэн бус институтуудын цогц
 E. Аль нь ч биш
10. Нийгмийн шинэчлэлийн \ модернизаци\ ойлголт аль нь вэ? (1 оноо)
 А. Хүний амьдралын чанар, нөхцөл дээшлэх зэрэг нийт нийгэмд хамаарахуйц зэрэг үрдагавар
 В. Нийгмийн хуучин байгууллыг шинэ байгууллаар эрс шинэчлэх үйл явц
 С. Нийгмийн амьдралын бүх хүрээг хамарсан, тодорхой цаг хугацаан дахь иж бүрэн суурь өөрчлөлт
 D. Оршин буй нийгмийнхээ үндсийг хөдлөлгүйгээр нийгмийн амьдралын аль нэгэн хүрээнд хэд хэдэн байнгын жигд, тогтвортой өөрчлөлтийн үйл явц
 E. Дээрх бүгд
11. Авилга гэж юу вэ? (2 оноо)
 А. Бусдын өгсөн аливаа зүйлийг өөрийн болгон ашиглах үйл ажиллагаа
 В. Бусдад аливаа зүйлийг нууцаар хахуульд анх, шан харамж авах
 С. Албан тушаалтан хувьдаа ашиг хонжоо олохын тулд эрх мэдлээ хууль бусаар ашиглан нийтийн болон хувь хүний хөрөнгийг завших
 D. Улсын эд хөрөнгийг албан тушаалаар далимдуулан санаатайгаар хувьдаа ашиглах
 E. Бүгд зөв
12. Тухайн нутаг дэвсгэр дээр бүлгийн бүх хүнийг хамруулахгүйгээр, харин тодорхой төлөөллийн үзүүлэлтүүдийг сонгон судалгаа хийдэг аргыг гэнэ. (2 оноо)
 А. Ерөнхий арга В. Тусгай арга С. Нээлттэй арга
 D. Нэлэнхүйн арга E. Түүвэрлэх арга
13. Татвараа төлөөд эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамжийн үйлчилгээ төрөөс авах нь улс төрийн эрх мэдлийн аль хэлбэрт хамаарах вэ? (1 оноо)
 А. Хүч хэрэглэх В. Наймаалцах С. Үүрэг үүсгэх
 D. Санал солилцох E. Нээлттэй байх
14. “Улс төр нь хүмүүсийг удирдах урлаг” гэж хэн хэлсэн бэ? (1 оноо)
 А. К. Маркс В. Р. Даль. С. Ф.Бро D. Аристотель E. Д. Истон
15. Монголчуудын “Төрийн минь сүлд өршөө” гэж төрөө дээдлэн залбирах нь аль легитим шинжийг илэрхийлж байна вэ? (2 оноо)
 А. Харизмат В. Хууль ёсны С. Үзэл суртлын D. Уламжлалт E. Ангийн
16. “Улс төрийн тогтолцоо бол хүлээн зөвшөөрөгдсөн хууль ёсны албадлагыг хэрэглэх буюухэрэглэхийг завдах замаар нэгдэн нягтрах, дасан зохицох чиг үүргийг хэрэгжүүлдэг харилцан хамаарал бүхий үйлдэл” гэж хэн тодорхойлсон бэ? (2 оноо)
 А. Г. Алмонд В. Д. Истон С. К.Маркс D. М. Вебер E. Т. Парсонс
17. УИХ-ын сонгуульд нэр дэвшүүлэх субъект аль нь вэ? (1 оноо)
 А. Сонирхлын бүлгүүд В. Ерөнхийлөгч С. Засгийн газар
 D. Дээд шүүхэд бүртгэлтэй намууд дангаараа буюу эвсэж E. Улсын нийт иргэд

18. Сонгогчдын олонхийн саналыг авсан нэр дэвшигчийг ялсанд тооцдог систем аль нь вэ? (1 оноо)
 А. Пропорциональ систем В. Можаритар систем С. Плюрал систем
 D. Холимог систем E. Намын систем
19. Эрх зүйт төрийн гол шинж аль нь вэ? (1 оноо)
 А. Иргэний эрх чөлөөг хангах
 B. Олон улсын эрх зүйн хэм хэмжээг хүлээн зөвшөөрөх
 C. Хуулийг дээдлэн сахих
 D. Ард түмний бүрэн эрхт байдлыг хангах
 E. Ардчилсан шүүхийг тогтоох
20. Холбооны улс аль нь вэ? (2 оноо)
 А. АНУ В. Монгол С. Испани D. Франц E. Кувейт
21. Иргэдийн улс төрийн нийцтэй оролцооны нөлөө бүхий суваг аль вэ? (2 оноо)
 А. Парламентын түвшинд олон нийтийн хэлэлцүүлгийн хэлбэр болох нээлттэй хуралдааныг явуулах
 B. Хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглан санал хүсэлтээ илэрхийлэх
 C. Парламентын мэдээлэл, сурталчилгааны төв байгуулах
 D. Аль нэг гишүүнд хандан хувийн захидал бичих
 E. Иргэдийн улс төрийн боловсрол олгох
22. Монгол улсын гадаад бодлогын тулгуур үндсийг аль субъект тодорхойлох вэ? (2 оноо)
 А. Ерөнхийлөгч В. УИХ С. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл
 D. Үндсэн хуулийн цэц E. Засгийн газар
23. Улс орнуудыг “ Нэгдмэл улс, Холбооны улс, Конфедераци” гэж ангилсан нь юугүндэс болгосон бэ? (2 оноо)
 А. Төрийн засаглалын хэлбэр В. Төрийн байгууламжын хэлбэр
 C. Улс төрийн дэглэмийн шинж D. Эрх мэдлийн хуваарилалт
 E. Аль нь ч биш
24. Улс төрийн намын гол шинжүүдээс илүүц зүйл олно уу. (2 оноо)
 А. Удирдах лидертэй В. Үзэл санааны, сайн дурын нэгдэлтэй
 C. Мөрийн хөтөлбөртэй D. Гишүүд дэмжигчидтэй
 E. Өөрийн удирдах болон орон нутгийн байгууллагыг багтаасан зохион байгуулалтын бүтэцтэй
25. Төрийг байгууламжийн хэлбэрээр нь ангилсаныг олно уу? (2 оноо)
 А. Ардчилсан, ардчилсан бус
 B. Хаант, Бүгд найрамдах
 C. Хэмжээт, хэмжээгүй эрхт хаант
 D. Парламентын, ерөнхийлөгчийн
 E. Холбооны, нэгдмэл, энгийн холбоо (конфедераци)
26. Эдийн засгийн хямрал гэсэн ойлголтод аль нь тохирохыг олно уу. (1 оноо)
 А. Эргэлтийн эхлэх цэг
 B. Эдийн засгийн огцом эргэлт
 C. Эдийн засгийн шилжилтийн хүнд бэрх байдал
 D. Эдийн засгийн тогтворгүй байдал
 E. Бүгд буруу

27. “Юуг-яаж- хэнд” гэсэн асуултад тохирох хариултыг олно уу. (2 оноо)
 А. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцоо
 В. Холимог эдийн засгийн тогтолцоо
 С. Чөлөөт зах зээлийн тогтолцоо
 D. Уламжлалт эдийн засгийн тогтолцоо
 E. Аль нь ч биш
28. Монгол улс дахь шатахуун импортолдог компаниуд шатахууны үнийг нэмэхээр тохиролцож байгаа нь ямар өрсөлдөөнт зах зээлийг илэрхийлэх вэ? (2 оноо)
 А. Төгс өрсөлдөөнт В. Олигополь С. Монопольт өрсөлдөөн
 D. Өрсөлдөөнт бус E. Монополь
29. Үүрэн телефоны оператор “ Скайтел “ компани бусад ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг компаниудыг бодвол хэвлэл, мэдээллийн хэрэгслээр зар сурталчилгаа түлхүү явуулжээ. Энэ нь өрсөлдөөний аль хэлбэрт хамаарах вэ? (1 оноо)
 А. Борлуулалтын өрсөлдөөн В. Үнийн өрсөлдөөн С. Технологийн өрсөлдөөн
 D. Эрэлтийг бий болгох чадварын өрсөлдөөн E. Хэрэглээ
30. Төрийн нийтийн зориулалттай өмчийн ангилалд хамааралгүй хариултыг олно уу. (2 оноо)
 А. Газрын хэвлий, түүний баялаг
 В. Иргэдэд өмчлүүлснээс бусад газар
 С. Улсын төвлөрсөн төсвийн хөрөнгө, төрийн бусад тусгай сан
 D. Ургамал, ан амьтны нөөц
 E. Ус, түүний доторхи баялаг
31. Улсын төсвийг бүрдүүлэхэд аль нь голлох вэ? (1 оноо)
 А. Торгуулиас олсон орлого В. Даатгалын төлбөр С. Татварын орлого
 D. Цалингаас авах шимтгэл E. Бүгд буруу
32. Мөнгөний үүрэгт хамааралгүй зүйл аль нь вэ? (1 оноо)
 А. Гүйлгээний хэрэгслийн
 В. Өртөгийн хэмжүүрийн
 С. Улсын төсвийг бүрдүүлэх, зарцуулах
 D. Хуримтлал, хадгаламжийн хэрэглүүрийн
 E. Бүгд зөв
33. Нийгэм эдийн засаг түргэн өөрчлөгдөж байгаа бүтцийг, ажиллах хүчин мэргэжлийн бүтэц дагаж өөрчлөгдөн хоцорсноос үүсдэг ажилгүйдлийн хэлбэр аль нь вэ? (1 оноо)
 А. Бүтцийн ажилгүйдэл В. Шилжилтийн ажилгүйдэл
 С. Мөчлөгийн ажилгүйдэл D. Ажилгүйдлийн түвшин
 E. Завсрын ажилгүйдэл
34. Эрх зүйн хэм хэмжээ, ёс суртахууны хэм хэмжээ, зан заншлын хэм хэмжээ зэрэг нь юм. (2 оноо)
 А. Соёлын нийлмэл элемент В. Соёлын хэм хэмжээний хэлбэр
 С. Соёлын албан бус хэм хэмжээ D. Соёлын универсал шинж
 E. Соёлын давамгайлах элемент
35. Монголд ядуурал буурахгүй байгаагийн гол шалтгаан аль нь вэ? (1 оноо)
 А. Үнийн өсөлт В. Ажилгүйдэл С. Өвчлөлт
 D. Архидалт E. Залхуурал
36. Хөрөнгийн хувь заяаг тодорхойлон шийдвэрлэх эрх мэдэлтэй байх нь өмчлөх эрхийн аль хэлбэр вэ? (2 оноо)
 А. Өмчийг эзэмших В. Ашиглах С. Бэлэглэх
 D. Захиран зарцуулах E. Худалдах

37. Монополь гэж юу вэ? (1 оноо)
 А. Бизнесийн үйл ажиллагаанд төрийн, аж ахуйн нэгж байгууллага, хувь хүмүүсийн эдэлж байгаа онцгой эрх
 В. Байгууллага, хүмүүс өөрсдийн ашиг сонирхолоо дээд зэргээр хангахын тулд бие биенээсээ өрсөж амжуулах гэсэн тэмцэл, эрмэлзэл, бодит үйл ажиллагаа
 С. Өөрсдийн нөлөө хүрээгээ өргөжүүлэхийн төлөө компаниудын явуулж буй тэмцэл.
 D. Бүх буюу ихэнх үйлдвэрлэлийг хяналтандаа аваад бүтээгдэхүүний үнэд нөлөөлж болох боломжийг олсон зах зээлийн бүтэц
 E. Дээрх бүгд
38. К. Маркс давхраажилтын гол хэмжигдэхүүнийг хэрхэн томъёолсон бэ? (1 оноо)
 А. Эд баялаг В. Нэр хүнд С. Эрх мэдэл D. Анги E. Боловсрол
39. Нийгмийн давхраажилтыг үүсгэж байгаа гол шалтгаан аль нь вэ? (1 оноо)
 А. Нийгмийн доторх хүмүүсийн эзлэх байр суурь
 В. Эд баялаг, эрх мэдэл, боловсрол
 С. Хязгаарлагдмал нөөцөөс хүртэх хувь хэмжээний тэгш бус байдал
 D. Нэр хүнд, ёс суртахуун, соёл
 E. Бүгд зөв
40. Бие хүний хүч чармайлт болон гавьяанаас хамаарсан статус аль нь вэ? (1 оноо)
 А. Олдмол статус В. Нөхцөлт статус С. Мастер статус
 D. Албан тушаалын статус E. Байгалиас заяасан статус
41. Ядууралд бусдаас илүү өртөх магадлалтай нийгмийн бүлгийг хууль тогтоомжинд юу гэж нэрлэдэг вэ? (1 оноо)
 А. Ядуу амьдралтай хүмүүс В. Нийгмийн эмзэг бүлэг С. Нийгмийн хамгаалал
 D. Нийгмээр халамжлуулдаг хэсэг E. Бие дааж амьдрах чадваргүй хүн
42. Микро бүлгийн үндсэн шинжийг тодорхойлно уу. (1 оноо)
 А. Орон зайн хувьд ойр байдаг В. Нийтлэг үйл ажиллагаагаар холбогдсон
 С. Бие биенээ шууд таньдаг D. Цөөн тооны гишүүдээс бүрдсэн
 E. Бүгд зөв
43. Язгуур угсааны хэв маягийн гол шинжийг олно уу. (1 оноо)
 А. Шатлан захирах тогтолцоо В. Эрх, үүргээ өв залгамжлан уламжлах
 С. Зан заншил D. Угсаа залгамжлал E. Бүгд зөв
44. Өрнөдийн орчин үеийн нийгмийн давхраажилд “хөх захтан”-уудад ямар хүмүүс багтдаг вэ? (1 оноо)
 А. Коллежээс дээш боловсролтой хүмүүс, төрийн албаны мэргэжилтнүүд
 В. Сургуулийн багш, жижиг бизнес эрхлэгчид, программистууд, бага тушаалын албан хаагчид
 С. Мэргэжилтэй ажилчид
 D. Мэргэжилгүй энгийн ажил эрхлэдэг хүмүүс
 E. Шинэ баячууд
45. Орчин үед боловсролыг хэрхэн ойлгох вэ? (2 оноо)
 А. Хүмүүжигчдэд хүмүүжүүлэгчээс нөлөөлөх нөлөөлөл
 В. Хүн төрөлхтний бүтээсэн соёлын өвийг ахмад үеэс хойч үедээ дамжуулах үйл явц
 С. Хүүхдийг өсгөх, ойлгох, хүмүүжүүлэх үйл явц
 D. Бие хүн төлөвших процесс, түүний үр дүн болсон мэдлэг, чадвар эзэмшүүлэх, амьдрах арга ухааны цогц
 E. Бүгд зөв

46. Дэлхий дахины буюу соёлын түгээмэл шинжтэй шашин аль нь вэ? (1 оноо)
 А. Протестант, ислам, күнз В. Индуизм, тотемизм, синтоизм
 С. Буддизм, христос, ислам D. Католик, протестант, үнэн алдартан
 E. Бүгд зөв
47. Мэндчилгээ, зочлох ёс, харилцааны хэв маяг, ажилдаа хандах хандлага, орон байр, хооллох, зэрэг нь юуг илэрхийлэх вэ? (2 оноо)
 А. Соёлын түгээмэл шинж В. Соёлын олон янз байдал
 С. Соёлын түгээмэл биш шинж D. Соёлын онцгой шинж E. Аль нь биш
48. Оюуны соёлын төрөлд хамааралгүй зүйл аль нь вэ? (1 оноо)
 А. Хууль зүйн хэм хэмжээ В. Зан заншил С. Ардын аман зохиол
 D. Тайхар чулуу E. Бүгд зөв
49. Ёс суртахууны хэм хэмжээ аль нь вэ? (1 оноо)
 А. Хөөрхөн, муухай В. Нүгэл, буян С. Сайн, муу
 D. Үнэн, худал E. Дээрх бүгд
50. Ази, Номхон далайн бүс нутгийг бүхэлд нь хамарсан өргөн хүрээтэй үйл ажиллагаа явуулдаг хоёр тивийн яриа хэлэлцээний механизм аль нь вэ? (1 оноо)
 А. АСЕАН В. ШХАБ С. АПЕК D. АРФ E. АСЕМ
51. Монгол улсын гадаад бодлогын үндсэн гол чиглэлийг олно уу. (2 оноо)
 А. Дэлхийн энхийг эрхэмлэгч орнуудтай хамтран ажиллах
 В. Хөгжингүй орнудаас эдийн засгийн туслалцаа авах
 С. Гадаад бодлогын нэн тэргүүнд ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай байх
 D. НҮБ-ын Аюулгүйн зөвлөлд хүсэлт гаргах
 E. Гадаад орнуудтай эдийн засгийн харилцааг хөгжүүлэх
52. ЮНЕСКО хэдэн онд байгуулагдсан бэ? (1 оноо)
 А. 1945 В. 1946 С. 1972 D. 1960 E. 1986
53. Монгол улсын Үндсэн хуульд эдийн засгийн талаар заасан зөв заалт аль нь вэ? (2 оноо)
 А. Олон хэвшил бүхий эдийн засагтай
 В. Төрийн өмч давамгайлсан эдийн засагтай
 С. Зах зээлийн өрсөлдөөн бүхий эдийн засагтай
 D. Хувийн өмч давамгайлсан эдийн засагтай
 E. Төрийн хяналт бүхий эдийн засагтай
54. Харьяа нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг . . . хариуцна. (2 оноо)
 А. Хурал, түүний тэргүүлэгчид В. ИТХ, Засаг дарга хамтарч
 С. Засаг дарга D. Орон нутгийн агентлаг E. ИНХ, Засаг дарга
55. Монгол улсын нутаг дэвсгэр, засаг захиргааны хувьд яаж хамаардаг вэ? (1 оноо)
 А. Аймаг, хот, сум, баг, дүүрэг хороо
 В. Аймаг, нийслэл, сум, баг, дүүрэг, хороо
 С. Аймаг, хот, дүүрэг, сум, хороо, баг
 D. Аймаг, нийслэл, сум, дүүрэг E. Бүгд буруу
56. Эрх зүйн харилцааны субъектүүдэд хамааралгүй нь аль нь вэ? (2 оноо)
 А. Эрх зүйн бүрэн чадамжтай, нас биед хүрсэн иргэд
 В. Албан ёсны байгууллага, аж ахуйн нэгж
 С. Төр
 D. Иргэдийн хувийн халдашгүй эрх, эрх чөлөө, тэгш байдал
 E. Тусгаар тогтносон улс

ХОЁРДУГААР ХЭСЭГ

2.1. Өгөгдлийг зөв тохируулна уу? (5 оноо)
(a,b,c,d,e тус бүрт харгалзах утгыг 1,2,3,4,5-аас сонго.)

- | | |
|-----------------------------|--|
| a. Туршилтын арга | 1. Нийгмийн үзэгдэл, үйл явцад судлаач өөрөө оролцох юм уу, оролцохгүй ажиглах замаар мэдээлэл цуглуулах арга |
| b. Асуулга (анкет)-ын арга | 2. Зориуд бэлтгэсэн тусгай орчин нөхцөлд үзэгдэл, үйл явцыг давтах, үргэлжлүүлэх замаар мэдээлэл цуглуулах арга |
| c. Бичиг баримт судлах арга | 3. Нийгмийн нэгдмэл үзэгдэл, үйл явцын зарим талыг хийсвэрлэн орхиод сонирхогдож буй тодорхой хэсэгт анхаарлаа төвлөрүүлэн судлах арга |
| d. Ажиглалтын арга | 4. Урьдчилан боловсруулсан асуулгын дагуу хувь хүн, хамт олон, бүлгийг судлах арга |
| e. Загварчлалын арга | 5. Үзэгдэл, үйл явцын тухай мэдээлэл агуулсан бичиг баримт, бусад материаллаг эх сурвалжид шинжилгээ хийх арга |

2.2 Өгөгдлийг зөв тохируулна уу? (5 оноо)
(a,b,c,d,e тус бүрт харгалзах утгыг 1,2,3,4,5-аас сонго.)

- | | |
|----------------------|---|
| a. Улс төрийн систем | 1. Улс төрийн системийн дотроос юм уу, түүнийг хүрээлэн байгаа экологийн, эдийн засгийн, соёлын зэрэг янз бүрийн системүүдээс гарч буй тулгалтууд |
| b. Дэмжлэг | 2. Төр, засгийн эрх мэдлийг ашиглан нийгмийн үнэт зүйлсийг нийгэмд байршуулах, хуваарилах үйл ажиллагаа |
| c. Шаардлага | 3. Төрийн бодлогын тодорхой илрэл болсон төрийн хууль тогтоомж, мэдээлэл сурталчилгаа |
| d. Шийдвэр, үйлдэл | 4. Оролт, гаралтын харилцан үйлдэл |
| e. Эргэх холбоо | 5. Улс төрийн системийг бүхэлд нь төрийн эрх баригчдын үйл ажиллагааг илэрхий дэмжсэн үйлдэл, ийм үйлдлийг хийхэд бэлэн сэтгэл зүйн байдал, аятай уур амьсгал |

2.3. Өгөгдлийг зөв тохируулна уу? (5 оноо)
(a,b,c,d,e тус бүрт харгалзах утгыг 1,2,3,4,5-аас сонго.)

- | | |
|------------------------------|--|
| a. Улс төрийн дэглэм | 1. Нийгмийн бүх үзэгдэлд туйлын хяналт тогтоохыг эрмэлздэг улс төрийн дэглэм |
| b. Охлократ ардчилсан дэглэм | 2. Улс төрийн системийн бүтцүүдийн тодорхой дэг журам бүхий харилцан холбоо, түүнчлэн засаглалыг хэрэгжүүлэх, улс төрийн зорилгод хүрэх аргуудын цогц |
| c. Тоталитар дэглэм | 3. Ардчилсан бус дэглэмээс ардчилсан дэглэмд шилжих шилжилтийн үеийн дэглэм |
| d. Авторитар дэглэм | 4. Нийгмийн амьдралд хамгийн бага оролцоотой дэглэм бөгөөд үндсэн үүрэг нь хулгай, дээрэм, хүчирхийлэл зэргээс хувь хүний эрх, эрх чөлөөг хамгаалахаар хязгаарлагддаг дэглэм |
| e. Либерал ардчилсан дэглэм | 5. Нэг буюу хэсэг хүмүүсийн захиран дарангуйлах улс төрийн дэглэм |

2.4. Өгөгдлийг зөв тохируулна уу?

(5 оноо)

(a,b,c,d,e тус бүрт харгалзах утгыг 1,2,3,4,5-аас сонго.)

- a. Татвар 1. Төрийн өмчийг /иргэдэд өмчлүүлснээс бусад газар, газрын хэвлий, баялаг, ой, усны нөөц /ашиглуулсны төлөө иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас авч улс, орон нутгийн төсөв болон тусгай санд төвлөрүүлж байгаа мөнгөн хөрөнгө
- b. Албан татвар 2. Хууль тогтоомжийн дагуу хуулийн этгээдүүд болон иргэдээс авч байгаа төрийн хураамж
- c. Хураамж 3. Заавал төлөх төлбөрийн хэлбэрээр аж ахуйн нэгж, иргэдээс хариу төлбөргүйгээр улс, орон нутгийн төсөвт хураадаг мөнгөн хөрөнгө
- d. Төлбөр 4. Аливаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас завсрын ямар нэгэн шат дамжлагагүйгээр орлогынх нь хэмжээтэй уялдуулан тогтоосон татвар
- e. Шууд татвар 5. Хууль тогтоомжын дагуу төрийн зохих байгууллагаас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад үйлчилгээ үзүүлсний төлөө тэднээс тухай бүр авч улс, орон нутгийн төсөвт оруулж байгаа мөнгөн хөрөнгө